

Хуучны гэрэл зургаас тухайн цагийг тольдох нь: Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны Хятад-Тайваний байдлыг ажиглах нь

Хуан Гожун¹

***Abstract:** The study of old photos is to search and analyze pictures over fifty years old in order to get a grip of the roles and relationships of the figures on the photos at the time they were taken, and can help to clarify the social background of the time. The purpose of the study is to depict the culture images of the society when the pictures were taken through the visual codes of the pictures, and to understand the political, cultural, and educational phenomena of the time, and the system of values of the contemporary society.*

By means of observing old pictures taken some fifty or sixty years ago, the figures on the pictures recaptured the circumstances of mainland China during the Chinese Civil War which they had gone through. Verified with the related contemporary historical records and documents, we can be certain that the civil war between the Nationalist Army and the Communist rebel had made a great impact over all of the people, military and civilian alike, in China. It is also verified that roughly 1.2 million soldiers and civilians retreated from mainland China to Taiwan had also made significant impact on Taiwan society at the same time and until this day.

Also, through analyses of many interviews and concerned documents, we can reconstruct a picture about the public opinion over cross-strait marriage at that time.

Keywords: old photos, visual codes, culture images, Nationalist-Communist civil war

¹ Huang Guorong/黃國榮. Улаанбаатар дахь Тайбэйн худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газрын төлөөлөгч

Нэг. Өмнөх үг

Хуучны гэрэл зураг судлал нь 1950-иад оноос өмнөх үеийн гэрэл зургийг цуглуулж, тэдгээрт дүн шинжилгээ хийх явдал юм. Ийм судалгаагаар хуучны гэрэл зураг дахь тухайн цаг үед хүрч, тэр үеийн хүн хоорондын болон нийгмийн харилцаа, бүр цаашилбал гэрэл зураг авагдсан үеийн нөхцөл байдал дүр төрхийг тайлбарлаж, нийгэм, улс төр, боловсрол, соёлын зэрэг олон төрлийн үнэт зүйл үзэгдлийг нь ойлгож судлах боломжийг олдог.

Энэхүү судалгаа 1949 онд Хятадын иргэний дайны улмаас Тайваньд зугтан гарсан Хубэй мужийн нэгэн настанд хадгалагдаж буй хуучны гэрэл зургуудад тулгуурлав. Чингэхдээ бага балчираас насанд хүрэх амьдралынх нь тухай дурсамж дүүрэн хуучны гэрэл зургуудад тухайн жил нутаг орноосоо дүрвэж цор ганцаар Тайвань хүрсэн эрэлхэг зоригт өсвөр насны хүү, түүний үеийн хүмүүсийн энгийн боловч өвөрмөц сонсууштай замнал бүхий нэгэн жарныг даван туулсан бас өөрийн мартагдсан явдлыг нэхэн сэргээж эргэцүүлэн бодож ярьсан өтөл буурал өндөр настны нууцлаг сэтгэлээс гарсан дурсамжийг нэгтгэн тэмдэглэсэн юм. Энэ үйл явдал өөрийн гэсэн давтагдашгүй онцлогтой ч үүнтэй ижил төстэй явдал тухайн цагийн хятадад цөөн биш юм. Эдгээр үүх түүхийг нэгтгэснээр нэгэн цаг үеийн үйл явдлыг бүрэн гүйцдээр бичиглэн үлдээх боломжтой болно.

Хоёр. Хуучин гэрэл зургийг шинжилж, эх газрын Хятад болон Тайваньд иргэний дайны үзүүлсэн нөлөөллийг ойлгох нь.

Хуучны гэрэл зургийг судалснаас хойш миний бие Тайваний энэ чиглэлийн судлаач Чэнь Чиужинь (陈秋瑾)-ий бүтээлдээ тэмдэглэсэн дараах мөрүүдийг олж үзэв. "...аливаа гэр бүлд зөвхөн гэр бүлийнхний хүрээнд л амаар дамжин уламжлагддаг үүх түүх гэж бий. Магадгүй үе цаг хоорондын завсарт болон төр засгийн хувьсал өөрчлөлтөд бичиж тэмдэглэх шаардлагагүй мэт, эсхүл гэр бүлийн гишүүд түүнийг бичиж тэмдэглэх чадваргүй, мөн хувь хүний амьдрал замнал нь ач холбогдол багатай мэт санагдаж болох юм. Цаг хугацааны өөрчлөлтөөр эдгээр түүх хэдэн үеийн дараа ул мөргүй алга болно. энэ мэт айл гэрийн үүх түүх энд тэнд тархай салангад чимээ аниргүйхэн оршсоор байна.

Хэрэв системтэйгээр бичиж эмхэлвэл адил бус цаг үеийн цэг дэх гэр бүлүүдийн түүхээс үе цагийн жанжин шугамыг хэлхэж болох бөгөөд олон олон өрх гэрийн үүх түүхээс нийгмийн өнгө төрхийг ч хэлхэн холбож болох юм. Эдгээр цэг шугам, өнгө төрхийн хэлхээс холбоос бол бидний өдөр тутмын амьдрал, бидний үүх түүх билээ.”² гэжээ.

Чэнь Чиужинь-ий өгүүлснийг иш үндэс болгож, энэхүү өгүүллээр дараах зорилгийг дэвшүүлсэн болно.

2.1. Жаран хэдэн жилийн өмнөх гэрэл зурганд ажиглалт хийх замаар, зурганд дүр нь үлдсэн хүнээр тухайн цагийн Хятадын коммунист нам болон Гоминдань нам хоорондын тэмцэл дэх эх газрын Хятадын нийгмийн төлөв байдлыг хүүрнүүлж, түүнээ орчин үеийн түүхийн судалгаатай уялдуулан Хятадын иргэний дайн нь тус улсын ард түмэнд асар ихээр нөлөөлсөн болохыг батлах.

2.2. Зурганд дүр нь үлдсэн хүний намтраар дамжин Тайваний ойр үеийн түүхэн баримтыг судлан мөшгөж, Гоминданы Засгийн газрын нэг сая гаруй цэрэг эрс Тайваньд ирсэнээр Тайваний нийгэмд үзүүлсэн тэдний нөлөөллийг нотлох.

2.3. Хүмүүсийн дурсамж яриа болон тэдэнтэй холбогдох баримтыг судалснаар тухайн үеийн Тайваний нийгэм, тайвань эмэгтэйчүүд ба эх газрын иргэдийн харилцаа, цаашлаад гэрлэлтийн талаарх үзэл хандлагийг нь ойлгох.

Гурав. 1940-өөд оны Хятад.

1937 оны 7 дугаар сарын 7-ны өдөр, Японы эзэнт гүрний арми Бээжин хотын захад байх “Лү Гоүчяо” (芦沟桥) гүүрэнд Хятадын цэрэг руу гал нээснээр Хятад, Японы дайныг эхлүүлсэн юм. Хятадын цэрэг Японы түрэмгий довтолгоонд удаа дараалан ялагдаж, Шанхай Наньжин зэрэг гол хотуудаа алдахад Иргэн улсын Засгийн газар Чунчин хот руу нүүхээс өөр аргагүйд хүрэв. 1941 он гэхэд Японы арми Хятадын газар нутгийн ихэнх хэсгийг эзлээд байв. Хятадын ард түмний амьдрал, эд хөрөнгөд урьд өмнө гарч байгаагүй зовлон нүүрлэсэн ч Хятадын цэрэг иргэд огтхон ч бууж өгөлгүй, эрс хатуу нэгэн сэтгэлээр дайсныг эсэргүүцсээр байсан юм.

² 陈秋瑾 (2010) 〈寻找台湾图像：老照片的故事〉，台北市：国立台湾历史博物馆，页20。

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*

1941 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Япон улс АНУ-ын Хавайн цэргийн бааз Сувдан эрэг рүү гэнэдүүлэн довтолсныхоо дараа Англи, Америкт дайн зарлав. АНУ дайны байдалд шилжиж улмаар Япон, Герман, Итали гэх тэнхлэгийн улсуудад дайн зарласнаар дэлхийн II дайн эхлэв. 1945 оны 8 дугаар сарын 6-ны өдөр Японы Хирошима хотод, 8 дугаар сарын 9-ний өдөр Нагасаки хотод АНУ атомын бөмбөг хаяв. 8 дугаар сарын 14-ний өдөр Японы эзэн хаан холбоотны цэрэгт үг дуугүй бууж өгөхөө мэдэгдсэнээр Хятад улс 8 жилийн туршид үргэлжилсэн эсэргүүцлийн дайнаа ялалтаар өндөрлүүлсэн билээ.



Зураг 1: 1945 оны 8 дугаар сарын 6. Хирошимад хаясан АНУ-ын атомын бөмбөгийн дайралт. Зургийг: <https://www.google.com.tw/search timetw.com>


Япон бууж өгсний дараахнаас засгийн эрхийн төлөөх тэмцэл Хятадын хоёр намын дунд дахин өрнөсөн билээ. Гоминданы Засгийн газар АНУ, Японы дэмжлэгээр Японы эзэмшиж байсан нутгийг хүлээн авах зөвшөөрлийг олж чадсан юм. Харин Коммунист нам нь ЗХУ-ын дэмжлэгээр зүүн хойд нутагт япончуудын үлдээсэн зэр зэвсэг, тоног төхөөрөмжийг хүлээн авч, зүүн хойд нутгийг хяналтандаа оруулан ихээхэн хүчин чадалтай болсноор Гоминданы Засгийн газартай засгийн эрхийн төлөө тэмцэлдэх болов. Талууд хэдийгээр Чунчины хэлэлцээр, Маршаллын зуучлалаар эвлэрсэн ч³ урьдын хэвээр дайтахаас зайлсхийхгүй байв.

1946 оны дунд үеэс хойш, Гоминданы Засгийн газрын цэрэг дайнд давуу байдлаа хадгалж нутгийн ихэнх хэсгийг эргүүлэн авснаар эсрэг талын цэргийн хүч чадал аажмаар бууран суларч байв. Гэвч 1947

3 薛化元 (1995) 〈中国近代史〉, 台北市: 三民书局, 页171~173。

оны 6, 7 сараас эхлэн газар бүрт Коммунист намын цэрэг довтолгоонд шилжжээ.

1948 оны эхээр улсын цэрэг (Иргэн улсын засгийн газрын цэрэг буюу Гоминдан намын цэрэг-Орч) зүүн хойд нутаг дахь тулаанд хүнд байдалд оров. Мөн оны сүүлч гэхэд Коммунист намын Линь Бяо (林彪)-гийн цэрэг зүүн хойд нутгийг бүхэлд нь эзлэн авчээ. 1949 оны 1 дүгээр сард Шү Банхуй (徐蚌会) -гийн байлдаанд улсын цэрэг дахин ялагдаж, улмаар 4, 5 дугаар сард Наньжин, Шанхай хот Коммунист намын цэрэгт эзлэгдэв. 10 дугаар сарын 1-ний өдөр Коммунист нам БНХАУ-ыг байгуулсныг зарлан тунхаглав. Иргэн улсын Засгийн газар Гуанжоу хотоос Чунчин-д, дараа нь Чэнду хотод эцэс сүүлдээ 12 дугаар сарын 7-ны өдөр Тайваньд шилжин нүүсэн билээ. 1950 оны 3 дугаар сарын 27-ны өдөр гэхэд Дундад Иргэн Улсын Засгийн газар эх газар дахь сүүлчийн түшиц газар болох Си Кан, Си Чан-г алдсанаар ХКН-ын цэрэг эх газрыг бүрмөсөн эзлэн авсан билээ.



Зураг 2: /зүүн/, зураг 3: /баруун/ ХКН 1949 оны 10 дугаар сарын 1-ний өдөр БНХАУ-г байгуулсан нь. Зургийг: <https://www.google.com.tw/search; politics.people.com.cn; history.huanqiu.com>.

Дөрөв. 1940-өөд оны Тайвань.

1937 онд Хятад, Японы дайн эхэлсний дараа Тайвань нь Японы эзэнт гүрний цэргийн бааз болсон юм. Япон улс Тайванийг колоничлох бодлогоо идэвхжүүлж тайваньчуудыг япон овог нэртэй болгохыг

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*

хүчлэн дэмжив. Мөн тайваньчуудыг сайн дурын цэргийн тогтолцоотой болгон туршсан юм. 1942 онд Японы засгийн газар Тайваний сайн дурын цэргийн тогтолцоог албан ёсоор хэрэгжүүлж, хожим дайны байдлаас шалтгаалан 1945 оноос тайваньчуудыг цэрэгт татах болсон билээ.

1945 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Япон улс үг дуугүй бууж өгснөө зарласны дараа, холбоотны цэргийн дээд ерөнхий командлагч Дуглас Макартурын тушаалаар Чан Кайши-д Тайвань дахь японы ялагдсан цэргийг хүлээн авах эрх олгов. 10 дугаар сарын 25-ны өдөр Иргэн улсын засгийн газар Чэнь И (陈仪)-г Тайбэйд илгээн, Японы клончлолын үеийн Тайваний амбан захирагч Андо Рикичи (安藤利吉)-ээс Тайванийг хүлээн авав. Иргэн улсын засгийн газар Тайвань мужийн засаг захиргааг байгуулж тэрхүү Чэнь И-г мужийн захирагч, ерөнхий командлагчаар томилсон билээ.



Зураг 4: 1945 оны 10 сарын 25 Чэнь И Тайбэй хотын Жуншань танхимд

Тайваний амбан захирагч Андо Рикичигээс Тайванийг хүлээн авав.

Зургийг: <https://www.google.com.tw/search; zh.wikipedia.org>

Тухайн үед тайваньчуудын олонх нь Иргэн улсын засгийн газрыг талархан угтаж айл бүр Тайванийг эргүүлэн авсныг баяр хөөртэйгээр тэмдэглэж, Хятадын Иргэн улсын засгийн газраас ирсэн төлөөлөгчдийг элэгсэг дотноор хүлээн авсан юм. Гэвч, засаг захиргаа, хууль цааз, хууль тогтоох болон цэргийн эрх мэдэл нэгэн хүний гарт төвлөрч, “Шинэ амбан сайдын захиргаа” нэртэй засаг захиргааны алба гарч ирсний дараа Тайваний сэхээтнүүдийн цээж дүүрэн хүсэл мөрөөдөл талаар болсон юм. Учир нь дайны дараа Тайваний улс төр, эдийн засаг,

нийгмийн бүх баялгийг энэхүү “Шинэ амбан сайдын захиргаа” нэрт тогтолцоо бараг дангаар эзэмших болсон юм.

Мужийн захирагчийн дарангуйллын захирах тогтолцооноос гадна Хятадын засгийн газрын албан тушаалтнууд эрх мэдлийг гартаа авав. Тэд өөрсдийн хүнээ татан авснаар авилга хээл хахууль даамжрах болж 1946 оны 1 дүгээр сарын сүүлчээс 2 дугаар сарын эхний арав хоногт гарсан “Ардын сонин”-д авилгатай холбоотой зургаан мэдээ нийтлэгдсэн нь тайваньчуудад хүндээр тусчээ. Тиймээс тухайн үед тайваньчуудын дунд “Тайванийг япончуудаас хүлээн авсан” гэх нэршлийг “тонон дээрэмдэлт” хэмээн ёгтлон хэлцэж байсан юм.⁴

Түүнчлэн “хүнд сурталтан”-ы мөлжлөг болон Тайвань долларыг хэт ихээр хэвлэн гаргаснаас шалтгаалан инфляци өсөхөд чихэр, будаагаараа алдартай Тайваньд тэдгээр бараа бүтээгдэхүүний үнэ Шанхай, Гонконг, Сямэнь зэрэг газруудынхаас үнэтэй болов. Тайваний ард түмэнд аюул нүүрлэж, амьдралынх нь нөхцөл туйлын хүндрэв. Эдийн засгийн доройтол, ард түмэн ядуурснаас болж нийгэмд хулгай дээрэм газар авсаар байв. Ард түмний эгдүүцэл зэвүүцлийг хамгийн их хүргэсэн зүйл нь цэрэг армийн сахилга бат муудсан явдал байлаа. Ялих шалихгүй зүйлээс цэрэг цагдаа нар ард түмнийг буу зэвсгээр айлган сүрдүүлж, бүр буудан хороох явдал ч гаргах болов. Цэрэг цагдаагийнхан энэ мэтээр ард иргэдээ дарлан самууруулж, дур зоргоор ашигласан явдал гаарсан нь тайваньчуудын хорсол жигшлийг туйлд нь хүргэж, хожим 2 дугаар сарын 28-ны хөдөлгөөний шалтгаан болсон билээ.⁵

2 дугаар сарын 28-ны хөдөлгөөн нь хэдэн арван мянган айл өрхийг үрэгдүүлснээр үл барам Тайваний хожмын улс төр, нийгэм сэтгэл зүй зэрэг бүх түвшинд асар хүчтэй нөлөө үзүүлсэн юм. Улс төрийн хувьд олон элит сэхээтнүүд хядагдаж, Тайваний дээд давхарга үгүй болсон нь Гоминьданы ноёрхолд ашигтайгаар эргэжээ. Нийгмийн хувьд, хохирогчдын гэр бүлүүд удаан хугацааны хохирол үзэж, нийгэмд хүйтэн хөндий байдал буй болж, улмаар мужийн харьяаллын чухал асуудлууд гарснаар тайваньчуудад тусгаар тогтнолын ухамсар буй болгоход хүргэсэн юм. Сэтгэл зүйн хувьд, тайвань хүний зан

4 薛化元等编撰；潘继道执笔（2004）〈台湾的历史〉，台北市：玉山社，页79。

5 曾逸昌（2009）〈悲情岛国四百年〉，台北市：曾逸昌，页261~268。

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*

чанар хүчтэй өөрчлөгдөж, удаан хугацааны турш колоничлолд байсан Тайваний ард түмэн нийгэм хамтын оюун санааны шарх сорвио арилган устгаж, өөртөө улам бүр итгэлтэй болов.⁶



Зураг 5: 1947.2.28-ны олон нийтийн эсэргүүцлийн анхны хөдөлгөөн.

Зургийг: <http://zh.wikipedia.org/wiki/维基百科网站>。

Хэдийгээр тухайн үед японтой энхийн хэлэлцээрт гарын үсэг зураагүй, мөн Тайваний олон улсын эрх зүйн хэм хэмжээ маргаантай хэвээр байсан ч ДИУ нь Тайванийг өөрийн нутаг дэвсгэрийн нэгэн муж гэж үзсэн Үндсэн хууль 1947 оны 12 сарын 25-нд хэрэгжих болов. Тиймээс Тайвань нь хэлбэрийн хувьд ДИУ-ын Үндсэн хуулийг хэрэгжүүлж байсан юм. Үнэндээ Иргэн улсын засгийн газар 1947 оны 7 сарын 18-ний өдөр “Самууныг давж, Үндсэн хуульт засаглалыг хэрэгжүүлэх дайчилгааны хөтөлбөр”, 1948 оны 4 сарын 18-нд дахин “Самуун үеийн түр цагийн зүйл заалтууд”-ыг тус тус баталж, удалгүй залгаад 1949 оны 5 сарын 20-нд Тайвань даяар онцгой байдал зарласан юм. Энэ бүгд нь колоний дарлалд хохирч хэлмэгдсэн тайваний ард түмний Иргэн улсын засгийн газрын мэдэлд шилжсэний дараа өөртөө эзэн болж, эрх чөлөөг эдэлнэ хэмээх найдлагийг нь талаар болгов. Харин ч бүр Тайваний ард түмэн урт хугацаанд “цагаан айдас”-тай цэргийн ноёрхолд дарлагдах болжээ.

Тав. Түүхэн нөхцөл

5.1. Ороо бусгаа, хүнд цагийн Хятад.

Японыг эсэргүүцсэн найман жилийн дайнд Хятадын хэдэн зуун мянган цэрэг эрс амь үрэгдэж, түүнээс ч илүү олон ард иргэд дайны

6 薛化元等编撰：潘继道执笔（2004）〈台湾的历史〉，台北市：玉山社，页85。

галаас зугтаж эх нутгаа орхин дүрвэгсдийн байдлаар амьдарч байв. Тэрхүү хүнд хүчир зовлонг өдөр хоногийг өөрийн биеэр туулсан алдарт зохиолч Чи Банюань (齐邦媛) “Их урсгалт мөрөн” хэмээх зохиолдоо тухайн үеийн байдлыг доорх мэтээр тэмдэглэсэн байдаг. “1937 оны 9 дүгээр сар болоход Наньжин хотын тал нь эзгүйрэн хоосорчээ. Бидний амьдардаг Нинхайд 10 дугаар сар гэхэд зөвхөн манай гэрийнхэн л үлдсэн байв. Хөршүүд яаран сандран нүүцгээсэн тул бүтэн хаагдаагүй хаалга, цонхнууд намрын салхинд хяхтнан дуугарч, гудамжаар дүүрэн цаасны хаягдал, хувцасны үлдэгдэл хийсч, нэг л тийм хоосон сүрдмээр байдал мэдрэгдэж байв.”⁷

Дайн өргөжихийн хэрээр дүрвэгсэд улам олширов. Японыг эсэргүүцэх дайны үед армийн захирагч асан Сунь Юаньлиан (孙元良) жанжин дайны аюулаас зугтан дүрвэж байсан тэр цагийн байдлыг дурсаж ярихдаа: “Би Гуйжоү-д тусламж үзүүлэхээр цэргээ Ханьжунгаас хөдөлгөн урт аянд явах зуур оюутнууд болон багш, үйлдвэр уул уурхай, төмөр замын ажилчид гэр бүлтийн хамт, мөн зуун мянга гаруй цэргийнхэн ар гэрийн хамт, боол болохыг үл хүссэн цэл залуухан хүмүүс, түүнчлэн эр эм, хөгшин залуу холилдсон ядарч зовсон уул тал дүүрэн дүрвэгч урсгалыг харсан бөгөөд эзлэгдсэн газар олон болох тусам ийм хүмүүс улам их болсоор байв. Замд гар тэргээс авхуулаад төрөл бүрийн машин сүлжилдэж байв. Зам дагуух тариан талбай өчүүхэн ч зүлэггүй болтлоо гишгэгдэн хүнээр дүүрч тэр чигтээ шавар балчиг болсон байсан. Дүрвэгсдийн хүрсэн газар бүрт хоол хүнс тэр дороо дуусч, тухайн газрын ард иргэд нь айж сандран дүрвэгсэдтэй нэгдэж байв. Шөнө болж хүйтрэхэд хүмүүс гал түлэн дулаацна. Түүдэг галыг тойрсон хөгшид, өвчтэй сул дорой хүмүүс хийгээд хүүхдүүдийн даарч, өлссөнөөс болсон зовж шаналан ёолох дуу чимээ тэр аяар хадна. Хаа сайгүй хавдсаж хөөсөн үхдэл цогцос. Алсыг бараалсан ч айлын бүтэн гэр үзэгдэхгүй, асар их зовлон зүдгүүрт хүний ертөнцөд цаашид хэрхэн амьдрах вэ гэсэн аймшигт мэдрэмж...”⁸

7 齐邦媛 (2009) 〈巨流河〉, 台北市: 天下远见出版股份有限公司, 页79。

8 胡志伟 (2007) 〈抗日名将孙元良访问记〉《传记文学》, 第91卷第1期, 页59-60。

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*



Зураг 6: Наньжин дахь Японы хядлага.

Зургийг: https://www.google.com.tw/search_photo.chinatimes.com

1945 онд Японыг эсэргүүцсэн дайн ялалтаар дуусахад эвдэрч сүйдсэн гэр байшинг засаж, төөрч хагацсан ах дүүс уулзалдан нийлж эхлэв. Гэвч 8 жилийн тэрхүү дайн дөнгөж дууссаны дараахан хоёр намын дотоодын дайн дэгдсэн билээ. Хятадын ард түмэнд түрхэн зуур боловч тэнхрэх боломж олдоогүй бөгөөд дахин тэнүүлч амьдрал үргэлжлэв. Энэхүү иргэний дайн хятадын ард түмэнд асар их хохирол үзүүлж, хэдэн зуун мянган гэр бүлийг дахин хэзээ ч учруулахгүйгээр салгасан юм.

Тайваний соёлын сайд асан алдарт зохиолч Лун Интай (龙应台)-н ээж Ин Мэйжунь (应美君) хагатай иргэний дайны үед буюу 1949 оны 1 дүгээр сард балчир жаахан ууган хүүгээ Хунань дахь гэртээ үлдээж, саяхан мэндэлсэн хоёр дахь хүүгээ аван нутгаа орхин гарсан юм. Асар хүнд зовлонгийн дунд уул, усыг гэтлэн байж Хайнань-д хүрэн, ухарч буй Иргэн улсын цэргийн усан онгоцонд дайгдан Тайваньд очжээ. Тэрбээр 1955 оны 9 дүгээр сар гэхэд л сая нэг юм анх удаа эх газрын нутаг руугаа буцаж очиж чаджээ.⁹

Дайн ширүүсэхийн хэрээр хоёр намын цэрэг ихээр хорогдож байдал улам хүнд болов. Цэрэг цөөрч хомсдоноос болж тулалдаж буй хоёр этгээд зам зуурт хүмүүсийг хүчээр цэрэгт элсүүлж байв. Яруу найрагч Гуангуан (管管) 1949 онд 19 настайдаа улсын цэргийн 8 дугаар их бууныханд баригдаж, хараагүй ээжийгээ орхин, Шаньдун нутгаасаа Тайвань луу хүчээр явсан юм.¹⁰

9 龙应台 (2009) 〈大江大海〉, 台北市: 天下杂志股份有限公司, 页36。

10 同上, 页111~117。

Энэ цөвүүн цаг үе оюутан залууст, боловсролд асар их нөлөө үзүүлсэн юм. Хичээлд явах боломжгүй болохоор үл барам дайны ноцтой үе ирэхэд гэр орноо орхихоос өөр аргагүй болж багш нараа дагалдан Тайваньд хүрч байв. Төвийн судалгааны академийн академич, алдарт түүхч Жан Үйфа (张玉法) Жинань, Шүбан-гийн дайны үеэр 14 настайдаа Шаньдун мужийн найман мянга гаруй сурагчдын хамт 1948 онд Тайванийг зорин хөдөлжээ. Тэд олон уулыг давж, урт замыг туулан 1949 оны 7 дугаар сард Тайваний Пөнгху-д хүрэхэд тэднээс таван мянган хүн л амьд үлдсэн байв.¹¹



Зураг 7: Иргэний дайны үеийн дүрвэж буй ард түмэн.

Зургийг: <https://www.google.com.tw/search history.voc.com.cn>

5.2. Хүнд хэцүү хувь заяа- колоницлогдсон Тайвань

Японы колоницлолоос ангижирч, эх орныхоо халуун дулаан тэврэлтийг хүсэн хүлээж байсан Тайванчуудын олж хүртсэн зүйл нь харин ч эсрэгээрээ бууны сум, хядлагаар дүүрсэн 2 дугаар сарын 28 байв. Мөн эх газарт дайнд ялагдсан ноёрхогч ангийн дагуулж ирсэн хэдэн сая оргодол цэрэг, дүрвэгчид байв. Эх газраас ирсэн эдгээр ноёрхогчид эд баялгийг эзэмшээд зогсохгүй Тайваний ард түмнийг урьд өмнө хэрэглэж дадаагүй байсан “Улсын хэл” гээчийг сурахыг шаардав. Энэ үйл явдалд тайванчууд таагүй хандаж байсан ч, 2 дугаар сарын 28-ны эмгэнэлт явдлаас болж хүлээн авахаас өөр аргагүйд хүрсэн юм.

¹¹ 同注10，页118~125。

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*



Зураг 8: 1949 оны 5дугаар сарын 20. Тайвань онц байдал зарлаж, “цагаан айдас”-ийг буй болгов. Зургийг: <https://www.google.com.tw/search; baibe.com>

Тайжунд удаан хугацаанд амьдарч, дөрвөн жилийн өмнө 90 хүрч өөд болсон алдарт яруу найрагч Чэнь Чиэнь Ү (陈千武) (уг нэр нь: Чэнь Үсион 陈武雄) дэлхийн II дайн дууссанаас нэг жилийн дараа Индонезийн Ява арлаас Тайваньд иржээ. Тэрбээр Ява арлаас Тайвань руу ирэх үеийн байдлаа дурсан санахдаа: *“Дайн дуусах үед би Ява-д байв. Тэнд хятад хүмүүс надаас, “Чи Тайвань луу буцах гэж байгаа юм уу? Чи болгоомжтой байх хэрэгтэй шүү! Гоминьдан тэнд маш хэрцгий байгаа гэсэн! Бид гоминьданы засгаас болж л энд зугтаж ирсэн. ... Чи буцаж очоод болгоомжтой байх хэрэгтэй, ямар нэгэн болгоомжгүй юм ярьж, бодолгүй зүйл хийж болохгүй.”*¹² хэмээн маш ихээр асууж, сануулж байв гэжээ.

*“Дайны дараахан Японы колони байсан, колони орны ард түмэн болох тайваньчуудын хувьд, Гоминдан Засгийг авсан нь засгийн газар л солигдсон болохоос урьдын хэвээр колони орны иргэд байх нь маш энгийн ойлголт байсан юм. Тэд зөвхөн толгойлогчоо л сольсон гэсэн үг. Тайваньчуудын сэтгэлд өчүүхэн ч өөрчлөлт гараагүй юм. Харин энэ удаад толгойлогч нь маш харгис тул тайваньчууд тэсч тэсвэрлэхийн аргагүйд хүрч 2 дугаар сарын 28-ны хэрэг явдлыг дэгдээсэн дэгдээсэн билээ.”*¹³

12 P4-041911-4

13 P4-041911-8



Зураг 9: Ченг Чизнь У (陈千武) Тайжуны дунд сургуулийн төгсөлтийн зураг, 1941 он.

Эх сурвалж: Шу Уйлань (许玉兰) / Чэнь Циэнь У-ийн гэргий/

Өдгөө 85 настай Луо Интай (罗应泰) бага насандаа Мяо Ли тосгонд амьдарч байхад нь Гоминьдан Засгийн цэрэг Тайваньд ирж Тайванийг авах үеийн байдлыг дурсан хэлэхдээ: *“Гоминьданы Засаг ирэх үед би бага ангийн сурагч байсан тул тод сайн санадаггүй юм. Ахмад томчуудын ярьж байсныг л сонссож байв. Япончууд ирж Тайванийг авахад хүмүүс маш ихээр эсэргүүцэн бослого гаргаж, тэмцэж байсан юм. Харин Гоминьданы цэрэг Тайваньд ирэх үед ард түмэн туйлын баяртайгаар хүлээн авсан билээ. Хожим нь Гоминьданы цэргийн дүрэм, сахилга бат сулрахыг хараад тайваньчууд итгэл найдвараа алдаж байлаа. Удалгүй түр цагийн хууль журам гарч цэргүүдийг газар дээр нь буудан хороох ялтай болсон тэр жил цэргийн тоо асар ихээр хорогдсон юм.”*¹⁴

*“Японы үед их хүнд байсан тэр байдал Гоминьданы Засгийн үед ч өөрчлөгдөөгүй билээ. Харин ч юмны үнэ асар ихээр өсч, мөнгөний хани тогтворгүй болсон бөгөөд тэр бүгд манайх шиг ядуу айлд маш хүнд тусч байв.”*¹⁵ гэжээ.

14 P3-121510-1

15 P3-121510-2

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*



Зураг 10: 1945 онд Жи Лун боомтод ирсэн Тайваний цэргийг хүлээн авах үед.

Зургийг: <https://www.google.com.tw/search; 360doc.com>

Хэдийгээр тайваньчуудын зарим нь эх газраас зугтаж ирсэн Гоминьданы Засгийн газрын армид, мөн түүнчлэн өөр мужуудаас ирсэн төрөл бүрийн мэргэжилтэй хүмүүст гадуурхсан тайгүй байдлаар хандаж байсан ч, харьцангуй нээлттэйгээр хүлээн авч байсан нь ч бас байв. Ялангуяа цэргийн бааз, суурины ойролцоо амьдардаг хүмүүс, ирж суусан цэрэг болон тэдний ар гэрийнхэнд арай илүү дотно хандаж байжээ.

Тайванийг эргүүлэн авсны дараа Тайжуны Фэнюан хотод бага ангийн багшаар ажиллаж байсан, эдүгээ 88 настай Шү Үйлань (許玉兰) хатагтай тухайн үеийн Тайваний эмэгтэйчүүд болон гадаад мужаас ирсэн эрэгтэйчүүд хоорондын харилцаа, гэрлэлтийн талаар “Мэдээж зарим хүмүүс гадаад мужийн хүнтэй яаж хуримлах юм гэж хэлэх байх. Зарим хүн бас ингэж бодохгүй ч байж болно, ихэнх эцэг эхчүүд бүр айхтар хориглохгүй, зарим нь харин хүсэхгүй. ...Миний найзууд, хамт ажилладаг хүмүүсийн зарим нь гадаад мужийн хүнтэй гэрлэсэн. Гадаад мужийн багш нар их байлаа, бид хамтдаа сайхан л байсан. Тэр багш нар хожим мөн л тайвань хүнтэй суусан, тэгээд сургуулийн дотуур байранд амьдарцгааж байсан...”¹⁶ хэмээн дурсаж байна.



Зураг 11: Шү Үйлань, 1945 он.

Багаасаа Линьбянь-д амьдарч, 18 настайдаа гадаад мужийн залуухан цэргийн захирагчтай суусан, эдүгээ 76 настай Жэн Мэй тухайн жил нөхөртэйгөө танилцаж байх үеийн нийгмийг дүрслэн, сэтгэгдлээ доорх байдлаар илэрхийлж байна. *“Намайг нөхөртэйгээ үерхэж байх үед гэрийнхэн ч эсэргүүцээгүй, бусад хүмүүс ч хов жив яриагүй, ямар нэгэн асуудал гараагүй юм. Миний хамт сурч байсан хүн ч гэсэн гадаад мужийн хүнтэй гэрлэсэн.”*¹⁷



Зураг 12: Жэн Мэй, 1957 онд.
Эх сурвалж: Жэн Мэй-гээс.

Зургаа. Шү (徐) овогтын залуу үеийн түүх

6.1. Орон нутгийн хувьсгал, бага насандаа эцэгээ алдсан нь.

Шү Цифан (徐慈舫), Хубэй мужийн Янсинь тосгоны хүн. Түүнийг 4 настайд эцэг нь Коммунист намын эсрэг тэмцэж эмгэнэлтэйгээр нас барсан, эх нь хүүгээ аван Үчан руу дүрвэн эцгийнхээ гэрт очжээ. 7 настайд нь Коммунист нам явсны дараа эхтэйгээ дахин Янсинь руу буцан өвөөтэйгөө хамтдаа амьдрал. 18 настайд нь Японыг эсэргүүцэх дайн ялахад Янсинь-г орхин Үчанд ирж ахлах сургуульд сурч байжээ.

17 P2-120310-7

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*

Шү овогт, “Коммунист нам тэр үед /1930 он/ газрын эзэдтэй маш нарийн тэмцэлдсэн. Тус нам газрыг ядуу хүмүүст тараан өгсөн юм. Сэхээтнүүдийг эсэргүү гэж үзэн устгаж байв. ...Тэр үед манай ээж 22 настай бэлэвсэрч билээ. Ээж оршуулгын ёслолоо дуусгамагц дараа шөнө дөлөөр биднийг дагуулан зугтаасан бөгөөд бид хурдхан явсаны ачаар л Үхань-д хурч чадсан юм”¹⁸ хэмээн дурсаж байна.

6.2. Урьдын гэнэдэл-хойшдын цээрлэл, номоо орхиод цэрэг болов.

1947 онд буюу иргэний дайны үеэр Үчан-д ахлах сургуульд суралцаж байсан Шү Цифан-гийн эцэг коммунист намыг эсэргүүцсэнээс болж нас баржээ. Шү Банхуй-гийн тулалдаанд Гоминдан цэрэг ялагдсаныг мэдээд, аль болох хурдан хугацаанд нутгаа орхин цэрэгт элсэх сонголтыг хийжээ.

Шү: “Би нөхцөл байдал буруу байгааг олж харсан, би аавыгаа яагаад нас барсаныг мэднэ, тийм учраас би ангийнхаа хүүхдүүдэд бид хурдан явах хэрэгтэй, Хонг Конгод хурч очихгүй л бол та нарт өөр очих газар байхгүй хэмээн хэлдэг байв. ... Нэг өдөр би Хуан Хэлоуны дэргэдүүр алхаж явахдаа агаарын цэргийн цаг уурын ангид цэрэг татаж байна гэсэн зарлалыг олж харсан юм. Тэгээд би шууд л бүртгүүлсэн. ...ийнхүү цэргийн хүн болон Сычуаний Тунле-н тавдугаар дивизид хүргэгдсэн юм.”¹⁹ хэмээн дурсаж байна.



Зураг 13: Шү Цифан /баруун талаасаа эхнийх нь/ Сычуань-ий Тунле-н тавдугаар дивизийн бэлтгэлд, найз нарын хамт, 1948 он. Эх сурвалж: Шү Цифан-аас

18 P1-120210-1

19 P1-120210-3

6.3. Ээжээсээ салаад, ганцаар Тайвань ниссэн нь.

Сичуаний Тунгле дахь 6 сарын курс төгсөөд, Чендү Фен Хуаншаны механикийн сургуульд 1 жил сурсан Шү Цифан нь Гоминданы ялагдлаас болж 20 гаруй найзын хамт Уханиас Тайгай руу нисчээ.

Шү: *“1938 оны гурав, дөрөвдүгээр сар гэхэд эзлэгдсэн тул арга мухардаж Тайвань руу нисэн Шинжү-д газардсан юм. Эндээсээ галт тэргээр Тайбэйд ирсэн. 1938 оны 4 дүгээр сарын 12-нд Тайбэйд буун “Үндэсний гурван үзэл”-ийн том улаан гэрлэн дэнг олж харсан юм. Тэгээд бид хоноглох буудал хайв. Миний санаж байгаагаар одоогийн Яньфиний хойд замаас холгүй газарт 1 хоноод, 2 дахь өдрийн өглөө Даньшүй-д хүрсэн билээ. Энэ нь Даньшүй-ний Ус цаг уурын Удирдах төв байгууллага буюу одоогийн Цаг уурын цэргийн анги юм. ...Бидний хорь гучаад хувь нь Тайваньд хуваарилагдсан. Би өөрөө Данишүйн Ус цаг уурын удирдах төв байгууллагад хуваарилагдсан ба одоогийн “Рен ай лу” дахь Цаг уурын төв юм.”²⁰ хэмээн дурсаж байна.*

6.4. Цэргийн нөхөд ахан дүүс мэт дотно байв.

Цэргүүдийн хамт Тайваньд ирсэн Шү Цифан тухайн үеийн олонхи сонсогч, цэргийн адил сэтгэл зүрхээрээ сургуульдаа хандаж байжээ. Тэрбээр ажиллах явцдаа цаг барьдаг, ажлын бус цагаар цэргүүдэд тусалж, тэднийг асран халамжилах бөгөөд хамтдаа амьдарч, ах дүү шиг л бие биендээ анхаарал халамж тавьдаг байв.

Шү: *“Бид тавуулаа Жун Шанбейн 53 дугаар гудамжинд байх байранд амьдарч, агаарын зэвсэгт хүчнийг удирдах төв газарт хооллодог байв. Амралтын өдрөөрөө гадуур гарч кино үзэж, салхилна. Бидний Ши Менътин-ий олон улсын кино театр байнга очдог байв. Энэ нь тухайн үедээ тохилог (агааржуулагчтай), гадаад кино гаргадаг ганц кино театр байсан юм. Цэргүүд тэнд төлбөргүйгээр кино үздэг байлаа.”²¹*

20 P1-120210-5

21 P1-120210-5



Зураг 14: Шү Цифан (баруунаас 6 дахь нь). Агаарын цэргийн цаг уурын төв байгууллагын хамт олны аялалын зураг. 1950 он. Эх сурвалж: Шү Цифан.

6.5. Хувь ерөөлгүй анхны дурлал.

Шү Цифан хамт олныхоо дунд нөхөрсөг найрсаг, удирдах хүмүүсийнхээ итгэлийг хүлээсэн, тэр ч бүү хэл эмэгтэйчүүдийн хайр хүндлэлийг татдаг нэгэн байв. 1950 оны 4 дүгээр сарын эхээр Илан Үжие-н цаг уурын станц суурьлуулах бэлтгэл ажлыг хийж байх үедээ Фүде Үжие-н бага сургуулийн залуу эмэгтэй багш нарт таалагджээ.

Шү: “Сургуулийн багш нар бидэнд их сайн байв. Тэд биднийг бусад хүмүүсээс өөрөөр хардаг байсан нь боловсролтой, соёлтой хүмүүс хэмээн боддогоос нь үүдэлтэй болов уу. Бид тэдгээр багш нарын сайн хандлагынх нь хариуд сургуульд нь очиж тэднийг хоолонд урьдаг байлаа. Тэр үед бид 25-26 орчим насны залуус байв. Нэгэн удаа бид Жан...дань (张○丹), Линь...чинь (林○琴) гэх багш бүсгүйчүүдтэй хамт архи ууцгаж маш хөгжилтэй байв. Тэд намайг архиар их дайлсан тул би согтож, ширээний булан мөргөж унаад толгойдоо 3 оёдол тавиулсан тэр үеийг сайн санадаг юм”²² хэмээн ярьж байна.

“Ямар нэгэн зүйлээ алдахад санаа зовох хэрэггүй, дараа азтай явдал тохиолдох нь дамжиггүй!” хэмээх үг бий. Гэмтэл авсан Шү Цифан эмчилгээ хийлгэж, боолтоо солиулах явцдаа Үжие тосгоны шүдний эмч Жан-гийн охинтой танилцаж, улмаар бие биедээ дурлажээ.

Шү: “Манай эсрэг талд шүдний эмчийнх байдаг байв. Тэр үед шүдний эмчийг арааны эмч гэж дууддаг байлаа. Нэг өдөр би боолтоо

22 P1-120210-9

солиулахаар тэднийд хүрэхэд Жан эмч: Манайх гадна шарх үздэггүй тул манайд боолт солих халдваргүйжүүлэх бинт байхгүй. Шүд эмчилэхэд тийм зүйл шаардлаггүй... гэв. Тэрбээр надад хандан би нэг охинтой юм. Тэр маань удахгүй Ланьян-ийн охидын дунд сургуулийг төгсөх гэж байгаа. Тэр Мандарин хэлээр ярьж чадна хэмээн өгүүлэв. Би охиныг нь дөрөв, таван цаг хүлээсний эцэст охин ирэхэд Жан эмч биднийг танилцуулав. Бидний ярилцаад сайн ойлголцож байв. Гэтэл тэр охин надаас мандарин хэлээр давтлага өгөхийг хүссэнд нь би зөвшөөрсөн билээ.”²³

“Түүнийг Жан гэдэг бөгөөд бидний бие биенээ гэсэн сэтгэл маш хурдан гүнзгийрч байв. Нэг удаа би түүнд түүний хичээлийн даалгаварт ирсэн нэгэн номыг тайлбарлан орчуулж туслав. Жан охин орчуулсан номоо сургуульдаа шалгуулахад бас ч гэж боломжийн, 88 гэсэн үнэлгээ авсан байв.”²⁴

“Жан надад талархаснаас илэрхийлж, намайг дагуулан Ланьян голын адаг дахь хулсан ойд шувуудыг сонирхуулж, өдөржин зугаацуулсан билээ...”²⁵



*Зураг 15: Жан охин. 1951 он.
Эх сурвалж: Шү Чифан өгөв. (фото зургийн эрхзүйн талаас бодолцож зургийг бүдгэрүүлэв.)*

Бидний энэ харилцааг Жан охины эцэг эх мэдээд охиноо гадаад мужийн хүнтэй учрав хэмээн дургүйцсэн юм. Жан охин эцэг эхийнхээ үгнээс зөрж чадахгүйн дээр миний бие нисэгч болох туйлын мөрөөдөлтэй байсан учраас энэхүү дурлалын харилцаа тасрахад хүрч билээ. Мартагдашгүй хайрын энэ түүх маань хэдийгээр хоёрхон жил үргэлжилсэн ч бид хоёрын хэн хэнийх нь зүрх сэтгэлд гүнзгий сэтгэгдэл

23 P1-120210-10

24 P1-120210-11

25 P1-120210-13

үлдээсэн юм. Бид хоёул өөр өөрийн амьдрал гэр бүлтэй болсон ч хагас зууны турш мартаж үл чадах хайрын түүх сэтгэлд хоногшжээ.

Шү: (Тэр бид хоёрын уулзалт) Тэр өдөр түүний ээж нь бидний уулздагийг мэдээд Жанг ихэд зэмлэжээ. Мөн Жанг хоолоо идчихээд усанд орохоор явах гэж байхад нь аав нь түүнийг дуудаж авчраад, Шү-тэй ямар учраас уулзаад байгааг нь асууж, ахин түүнтэй уулзаж болохгүй хэмээн хэлсэн байжээ. Жанг охин аав, ээждээ зэмлүүлж загнуулахаас үл эмээн хэд хэдэн удаа надтай уулзсан боловч тэр бүгдийг түүний аав нь мэдэж байсан билээ. Бидний хэн хэн нь ийнхүү шаналалд автсан юм. Энэ байдал бол нааштай арга биш гэдгийг би мэдэрсэн тул 2 жилийн харилцаа эцэс болж, 1941 оны гуравдугаар сард би түүнээс холдон явсан юм.²⁶

Би түүнийг орхих болсон эхний шалтгаан бол Жанг охин тун аймхай нэгэн байв. Тэр бидний хайр дурлалын ээдрээт байдал, бие биедээ шаналан түмүүлж байгаагаа эцэг эхдээ шууд хэлж чадахгүй байсан нь намайг түүнийг орхин одоход нөлөөлсөн юм. Удаах шалтгаан нь миний нисгэгч болох мөрөөдөлтэй минь холбоотой. Учир нь нас хэтэрвэл нисгэгчийн шалгалтад орох боломжгүй болох тул түүнийг орхин явж, даруйхан номоо үзэж шалгалтандаа оролцох явдал байв. Би Тайбейд очоод Тай даргатай уулзан Үжсие-г орхиж явах болсоноо хэлэхэд; тэрээр, чи тэнд найз охинтой биш билүү хэмээн асууж билээ. Би түүнд учир байдлаа бүгдийг хэлсэн тул намайг хүний нөөцийн асуудал эрхлэх газарт шилжүүлсэн юм. Би Тайжууд очих хүсэлтэй хэмээн бөглөсөн боловч тэнд орон тоо байгаагүй мэт тул намайг Тайдун руу шилжүүлж билээ.²⁷

Зургаа. Тоорын цэцэг дэлгэрсэн мэт зүс царай, мэдлэг хосолсон нь.

Шү Цифан Илань-аас Тайдун-д ирээд, тэндээсээ Ганьшань-д ирж Агаарын нисэх хүчний академид суралцав. Хожим нь нисэх хүчний холбооны сургуульд шилжжээ. Тэрбээр тэгш сайхан бие бялдартай, боловсролтой нэгэн байв. Тиймээс түүнд сургуульд суралцах явцад,

26 P1-120210-14

27 P1-120210-15

мөн сургуулиа төгсөөд ангидаа хувиарлагдан ирэхэд нь ч гэсэн олон охид сэтгэлээ илчилж байсан бөгөөд зарим нь бүр гэрлэх санал тавьдаг байв.



Зураг 16. Шү Цифан. 1953 он
Эх сурвалж: Шү Цифан.

Шү: *Илань-аас явснаасаа би хойш олон охидтой харилцжээ. Үсчний газрын эзний охин ч бас надад их сайн байсан юм.*²⁸ *Бид шинэ оюутнуудаа дагуулан сургах тул долоо хоногийн турш чөлөө зав ихтэй байлаа. Бүр бямба гариг бүр маш чөлөөтэй байх бөгөөд сургуульдаа буцаж очихгүйгээр гадуур цугаацаж наадаж болдог байв...* “Шинэ оюутны нийгэмлэг” нь нисэх хүчний сургуулийн хамгийн сайн нь бөгөөд дайны үеэс өнөөг хүртэл бямба гариг бүрт бүжиг зохионо. Тус нийгэмлэг нь Пиндуны “Гургалдайн клуб”, Ганшань-ий “Шинэ оюутны нийгэмлэг” шиг тоног төхөөрөмжөөр сайн тоноглогдсон байлаа. Тухайн үеийн цэргүүд, ялангуяа нисэх хүчний цэргүүд их чөлөөтэй байсан юм. Энгийн хүмүүсийн бодлоор нисэх хүчний цэргүүд хуурай замын цэргийнхнээс 2 шатаар, далайн цэргийнхнээс 1 шатаар илүү хангамжтай гэж боддог байв. ...Тайвань охид нисэх хүчнийхэнтэй найзлах дуртай ба хувцаслалтандаа их анхаарал хандуулдаг байв.”²⁹

Намайг гэрлэх үед эхнэрийн талын гэрчээр Пинь бүсгүй байлцсан юм. Пинь бид хоёр нас чацуу ч тэрбээр миний доод ангид сурдаг байсан бөгөөд надад тун сайн ханддаг байв. Тэр бид хоёр яагаад ийм дотно байснаа би өөрөө ч мэддэггүй юм. Энэ бүсгүйтэй нөхөрлөж байхдаа би эхнэртэйгээ танилцаагүй байсан билээ. Пинь бүсгүй маш үнэнч, надад үнэн сэтгэлээсээ хандах бөгөөд бид хамт кино үзэж, тоглон зугаацдаг байлаа. Тэрбээр надад гүн гүнзгий сэтгэгдэл

28 P1-120310-20

29 P1-120310-15

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*

төрүүлж чадсан ч надад бол ямар нэгэн өөр санаа бодол байгаагүй бөгөөд сайндаа л элдвийг ярилцацгаадаг байсан юм. Би эхнэртэйгээ гэрлэх үедээ түүнийг эхнэрийн талын гэрчээр урьсанд тэрбээр маш их баярлаж байсан билээ.³⁰



Зураг 17: Нисэх хүчний технологийн сургуулийн электроникийн 18 дугаар төгсөлтийн зураг. 1953 он. Эх сурвалж: Шү Цифан.

Долоо. Гэр бүл болж суурьшсан нь

Шү Цифан нисэх хүчний холбооны сургуульд байхдаа идэвх чармайлттай сайн суралцахын зэрэгцээ радио, дуу тохируулагчийг маш сайн засаж сурчээ. Сургуулиа төгссөний дараа тэрбээр Пиндун-ы Жиадун цамхагийн үйлчилгээнд хуваарилагдав. Тэрбээр ажилдаа эзэн болохын зэрэгцээ өөрийн ур чадвараа ашиглан бага төлбөртэй засвар үйлчилгээ хийх болов. Чингэж явахдаа Женмей (郑梅) хэмээн сайхан хүүхэнтэй танилцаж үерхжээ. Энэ байдлыг нь хүүхний эцэг эх зөвшөөрсөн тул 1959 оны 6 дугаар сард тэд нэг гэрт орж улмаар 3 охин, 1 хүүтэй болцгоосон байна. Тэд олон удаа энд тэнд шилжин ажилласаар 30 хэдэн жилийн өмнө цэргээс тэтгэвэрт гарсан байна. Өдгөө тэд Тайваний Шинбэй хотын Жунхө хороололд аж төрж, ном уншин спортоор хичээллэн насны буянаа эдлэж сууна.

30 P1-120310-13



Зураг 18. Шү Цифан 1959 он.
Эх сурвалж: Шү Цифан.



Зураг 19. Шү Цифан, Жен
Мей болон хоёр талын
гэрчүүдийн хамт, 1959 он.
Эх сурвалж: Шү Цифан.

Шү: Би Жиадун-д мэргэжил чадвараараа бусдаас илүү байв. Тухайн үед хүмүүс гэрийнхээ радиог засч угсарч чаддаггүй байлаа. Сургуулиа төгссөний дараа би мөнгө хуримтлуулсаар цахилгаан хэрэгслийн засварын багаж худалдан аваад радио хэрэгслийг угсарч засдаг болсон юм. Анхны удаа долоо хоногийн хугацааг зарцуулан байж гадаадын долгион барих нэг радио угсарч чадсандаа маш их баярлаж байлаа. Тэр цагт радио угсрах нь маш их ашигтай ажил байлаа шүү дээ. Нэг радио угсарахад 700 тайвань доллар зарцуулж, 1200-гаар зардаг байв. Тухайн үед Шиань-ий захиргааны ажилтад 400 тайвань долларын цалинтай байхад би нэг өдрийн 450-ын ашиг олж байлаа. Дараа нь би нэг радиог хоёр хоногт угсарч чаддаг болсон шүү. Энэ ажил маань намайг эмч хүнээс илүү орлогтой нэгэн болгосон юм. Миний том охиныг төрөх тэр үед ханиад өвчнийг 30 тайвань доллараар үзэж, эмчилдэг байсныг би санаж байна. Тэр үед би радио засчихаад л 50-ыг авна, сэлбэгт 20 орчмыг л зарцуулдаг байлаа. Тэр үед цахилгааны засвар хийдэг хүн маш цөөхөн байсан юм.³¹ Би Линьбэй-д эхнэртэйгээ танилцсан тухайгаа яривал, нэг удаа би ирээдүйн эхнэрийнхээ авга ахынх нь хувцасны дэлгүүрт очиж билээ. Тэр дэлгүүр одоогийнхоор бол бараг бараа худалдааны компанитай төстэй юм. Тэнд шүдний оо, энгэсэг, саван, хүүхэд том хүний хувцас гэх мэт төрөл

31 P1-120210-20

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*

бүрийн юмс байдаг ажээ. Дэлгүүрт ирээдүйн эхнэртэйгээ ярилцаж байтал тэрбээр “миний радио эвдэрсэн” хэмээн хэлэхэд нь би түүнд “Би засаж болох юм, гэхдээ засварын багажаа авч ирсэнгүй, дараа ирж засаж өгье” хэмээн хэлсэн юм. Тэгээд би тэндээс гагнуурын аппарат аваад харьж билээ. Би радио засварлаж, угсрах захиалганд дарагдсан байсан тул ирээдүйн эхнэртэй амласнаа мартчихаж билээ. Захиалгын ажлаа хийж дуусаад л сая нэг юм амласнаа санаж, түүнийхээ радиог засахаар багажаа бариад очсон билээ. Энэ хооронд нэгэнтээ хагас сарын хугацаа өнгөрсөн байв. Намайг очих үед тэрбээр надад хандан та юу худалдаж авах вэ хэмээн асуухад нь би түүнд радиог тань засахаар ирсэн гэдгээ хэлэв. Чингэхэд тэрбээр Линьбэй-д радио засварын газар байхгүй тул Цаожоу-д аваачиж засуулчихсан, энэ радио ингээж л засагдах учиртай байжээ³² хэмээж билээ.

Жен: Би ажил хийж эхэлж байсан тул хэрхэн хүн болох, хэрхэн ажил хийхийг дөнгөж л мэдэрч байлаа. Би ямар ч хүн танихгүй бөгөөд нээлттэй хүн биш гэдгээ харьцангуй оройтож мэдсэн юм. Залуучууд намайг өдөж хоргооход би тэднийг тоодоггүй байлаа. Харин хань маань л намайг тойглож надад хайртай болсон тэр үед би ээждээ энэ тухайгаа хэлж билээ. Ээж маань аливаа асуудлыг ихэнхдээ мэдэж шийдвэрлэдэг, ээж юу гэнэ аав зөвшөөрдөг байж билээ. Тиймээс би ээжээсээ бидний явдлын тухай асуухад ээж маань дургүйцээгүйгээр үл барам дэмжиж билээ. Ингээд л би ханьтайгаа харилцах болсон юм даа.

Хожим ээж маань надад “Тэр залуу насан туршийн ур чадвартай болсон тул өлсөхийн зовлон үзэхгүй. Тухайн үед би охин чамдаа их санаа зовдог байлаа. Охин маань ажил олж хийж чадахгүй, аливаа зүйлийг хийж чадахгүй хэмээн бодно. Харин одоо энэ залууг түшин амьдарвал өлсөхийн зовлон үзэхгүй юм байна хэмээн бодсон тул зөвшөөрсөн юм юм”³³ хэмээж билээ.

32 P1-120210-21

33 P2-120310-5



Зураг 20: Шү Цифан, Жен Мей нар зочдын хамт, Пиндун хотын Жимейлоу ресторан. 1959 он. Эх сурвалж: Шү Цифан.

ДҮГНЭЛТ

Бага балчир ахуйд эцэг нь коммунист намын газрын эздийн эсрэг хийсэн тэмцлийн үед асар их дарамтыг үзсэн аймшигт дурсамжийн улмаас Шү Цифан эх газрын Хятад эзлэгдэхийн өмнөхөн ахлах сургуульд орох байсан ч төрөлх нутгаасаа хагацан цэрэгт элсэх шийдвэрийг өөрөө гаргажээ. Хожим нь ганц биеэрээ Тайваньд ирж, төрсөн эх, гэр орноосоо үүрд хагацсан байна. Шү Цифан-тай адил шалтгаанаар дайн самуунаас зугтан, цэрэгт элсэх шийдвэр гаргаж Тайваньд очсон залуус олон байжээ. Тэдгээр залуусын зарим нь сайн дураар цэрэгт элссэн бол, зарим нь дайчилгаагаар цэрэгт татагджээ. Нөгөөтэйгүүр, цагаачлан гарсан оюутны тоо бараг арван мянгаад байв.

Хятадад тухайн үед өрх амын (гэр бүлийн) бүртгэл хөтөлдөггүй байсан тул дайн самуунтай тэр цагт цэргийн насанд хүрээгүй олон залуус цэрэгт явахын тулд насаа нэмэх үзэгдэл түгээмэл байжээ. Харин дайны дараа эх газрын Хятадын олон иргэд Тайваньд ирээд суралцах ажиллахын тулд насаа хасаж бүртгүүлдэг байв. Тухайлбал, энэхүү

*Хубэй залуугийн явдлаас 1940-1950 оны
Хятад-Тайваний байдлыг ажиглах нь*

өгүүллийн гол дүр Тайваньд ирээд насаа 4 насаар дарж бүртгүүлсэн юм. Сонирхолтой нь 1979 оны Хятадын өөрчлөлт, шинэчлэлт, нээлттэй бодлогын дараа Тайваний олон бизнесменүүд Хятадад ирж хөрөнгө оруулалт хийн, удаан хугацаагаар оршин суух болсон явдал юм. Тайваний зарим бизнесмен хөнгөлөлт эдлэхийн тулд Хятадын иргэний үнэмлэх авах хүсэлт гаргаж байсан бөгөөд тус хүсэлт дээрээ төрсөн огноогоо татаж бичиж байжээ. Өгүүлэгчийн ахлах сургуулийн нэг ангийн найз Ду хэмээгч нь Тайваньд байсан наснаасаа 10 нас залуугаар Хятадаас авсан иргэний үнэмлэх дээрээ бүртгүүлж байсныг жишээ болгон дурдаж болох байна.

Эх газрын Хятадаас Тайваньд зугтан очсон тэдгээр цэрэг, оюутнууд тэнд хэдэн жил амьдарсан хойноо төрөлх Хятадаа ойрын хугацаанд очих боломжгүй гэдгээ мэдсэн тул аажимдаа Тайваньд гэр бүл зохиож, суурьших бодолтой болцгоожээ. Иймээс тэдгээр залуус Тайваний уугуул эмэгтэйчүүдтэй гэрлэх нь түгээмэл байв. Эх газрын Хятадын зүүн өмнөд далайн эргийн мужуудаас тухайн цагт ойролцоогоор 1.2 сая хүн Тайваньд ирсэн байна. Тайваний уугуул иргэд тэдгээр шилжин ирэгсдийг “гадаад мужийнхан” хэмээдэг байсан бөгөөд тэднээс төрсөн хүүхдүүдийг, түүнчлэн тэдэнтэй гэрлэсэн тайвань эмэгтэйгээс төрсөн хүүхдийг ч ялгалгүй “гадаад мужийнхний хоёр дахь үе” хэмээн нэрийддэг байв.

1950-иад оны үеийн Тайваньд гадаад дотоод мужийнхний хооронд сөргөлдөх үзэгдэл байгаагүй ч нутгийн уугуул хүмүүсийн зарим нь окидоо гадаад мужийнхантай үерхүүлэх дургүй байснаар үл барам “Лазан хүүхэн л гадаад мужийнхантай гэрлэдэг” хэмээн ярьдаг байв. Гэсэн ч Тайваний уугуул иргэдийн дунд гадаад мужийнхантай найзлахыг хүсдэг, түүгээр ч барахгүй гэрлэх хүн нэлээд байсан юм. Ялангуяа цэргийн баазийнхан болон тэдний ойролцоох уугуул иргэд хоорондоо гэр бүл болж байв. Энэ бүгд энэхүү ярилцлага болон хожим бидний хийсэн судалгаагаар нотлогдсон юм.

“Мужийн харьяаллын асуудал” сүүлийн 10 хэдэн жилд Тайваньд яригдах болсон юм. Ялангуяа сонгуулийн үеэр улс төрчид хэвлэл мэдээллээр ноцтой асуудал болгон мэдэгдэж уг нөхцөл байдлыг санаатайгаар хүндрүүлэх нь хэрээс хэтрэх болов.

Гоминьдан намын Засгийн газар болон цэрэг арми нь Хятадын иргэний дайнд ялагдаж, 1949 онд Тайваньд ухарч очсоноос хойш Тайвань нь тус намын захиргаанд байсаар иржээ. Гоминьдан намын эрх баригчид олон жилийн турш өөрсдийгөө Хятад хүн хэмээн үзсээр байгаа бөгөөд Хятадыг нэгтгэх зорилго нэг л өдөр биелэнэ хэмээн Тайваньчуудад сануулж, ухуулсаар байна.

Хэдий тийм ч, Тайваний ардчилалын хөгжил хийгээд тус газарт нутагших үзэгдэл гүнзгийрсний улмаас эх газрын Хятадыг нэгтгэх үзэлтэн болон өөрсдийгөө хятад хэмээн үзэх Тайвань хүн улам бүр багассаар байгаа юм.

2016 оны 1 дүгээр сард Тайваньд Ерөнхийлөгчийн болон парламентын сонгууль явагдаж, үр дүнд нь уугуул иргэдийн нам хэмээгдсэн Ардчилсан нам “гадаад мужийнхан”-ы нам хэмээгдсэн Гоминьдан намыг ялсан билээ. Тэд засгийн эрхийг барих болсон төдийгүй парламентын олонхийн суудлыг авсан юм. Энэ сонгуулийн үр дүнгээс бид XXI зууны Тайвань болон 1950-иад оны Тайваны хоорондох асар их ялгааг харж болох бөгөөд 1950-иад оны Тайвань нь Хятад хүний Тайвань байсан бол, одоох Тайвань нь тайвань иргэдийн Тайвань болсон гэдгийг маш тодорхой мэдэж болохоор байна.

Хятад хэлнээс орчуулсан:
Олон улсын харилцааны хүрээлэнгийн ЭША,
доктор Ph.D Н.Сувд-Эрдэнэ.

Ашигласан материал:

1. 林桶法 (2009) 〈1949大撤退〉, 台北市: 联经。
2. 陈秋瑾 (2010) 〈寻找台湾图像: 老照片的故事〉, 台北市: 国立台湾历史博物馆。
3. 薛化元 (1995) 〈中国近代史〉, 台北市: 三民书局。
4. 薛化元等编撰; 潘继道执笔 (2004) 〈台湾的历史〉, 台北市: 玉山社。
5. 薛化元 (2000) 〈台湾历史〉, 台北市: 大中国。
6. 薛化元 (1995) 〈中国现代史〉, 台北市: 三民。
7. 林博文 (2009) 〈1949石破天惊的一年〉, 台北市: 时报文化。
8. 黎东方 (1993) 〈中华民国简史〉, 台北市: 幼狮。
9. 曾逸昌 (2009) 〈悲情岛国四百年〉, 台北市: 曾逸昌。
10. 龙应台 (2009) 〈大江大海〉, 台北市: 天下杂志股份有限公司。
11. 齐邦媛 (2009) 〈巨流河〉, 台北市: 天下远见出版股份有限公司。
12. 山琦繁树·野上矫介 (1990) 〈1660-1930台湾史〉, 台北市, 武陵出版社。
13. 胡志伟 (2007) 〈抗日